



Аудитын код: САГ-2018/405/СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу:

Цахим хуудас: www.audit.mn

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер С.Оюунгэрэл
Утас: 261885 Цахим хаяг: oyungerels@audit.gov.mn

Аудитор Б.Цэгмиддорж
Утас 261740 Цахим хаяг: tsegmiddorjd@audit.gov.mn

Гэрээгээр ажил гүйцэтгэсэн:
Бодьтусгал-аудит ХХК –ийн захирал З.Мягмарсүрэн
Утас: 11305165 Цахим хаяг: zmiiga999@gmail.com

Аудитор Г.Юмчмаа
Утас: 99908730 Цахим хаяг: g.yumchmaa1222@yahoo.com

Улаанбаатар хот



АГУУЛГА

1	Аудитын гэрчилгээ	0
2	Аудитын тайлан	2
2.1	Оршил	2
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	2
2.3	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	3
2.4	Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	4
2.5	Дотоод хяналт	4
2.6	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	4
2.7	Шилэн дансны мэдээлэл.....	5
2.8	Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар	5
2.9	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл	5
2.9.1	Дотоод хяналтын талаар	4
2.10	Анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	6
2.11	Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд	6
2.12	Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл	6
2.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	6
2.14	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар:.....	6
2.15	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	6
3	Менежментийн захидал.....	7
3.1	Дотоод хяналтын талаар.....	9
4	Аудит хийгдсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	12
4.1	Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	12
4.2	Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	13
4.3	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	14
4.5	Төсвийн гүйцэтгэлийн тохируулгын тайлан	15
4.6	Соёл, урлаг хөгжүүлэх сангийн менежментийн захидлын хариу.....	16

1. Аудитын гэрчилгээ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

СОЁЛ, УРЛАГ ХӨГЖҮҮЛЭХ САНГИЙН
УДИРДЛАГА, БСШУС-ИЙН ЯАМНЫ
САНХҮҮ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛЫН
ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ
Х.ГАЛСАНХҮҮ ТАНАА

2018.03.21 № 06/768
танай _____ -ны № _____ -т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Соёл, урлаг хөгжүүлэх сангийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Соёл, урлаг хөгжүүлэх сангийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Соёл, урлаг хөгжүүлэх сангийн 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

\\10.10.10.20\Bichig_Kheregi\Yawsan_Bichig\2018\0321SAG7.Docx

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

Үүрэг, хариуцлага

Тус сангийн удирдлага нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *В. М.* Ц.НАРАНЧИМЭГ

2 АУДИТЫН ТАЙЛАН

2.1 Оршил

Соёл, урлаг хөгжүүлэх сангийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланг Соёл, урлаг хөгжүүлэх сангийн удирдлагад танилцуулж байна.

Энэхүү тайланд танай сангийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд үйлчлүүлэгчийн дотоод хяналт хангалтгүй байгаа тухай зөвлөмжинд тусгалаа.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулсан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Соёл, урлаг хөгжүүлэх сангийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.


Аудитыг Төрийн аудитын тухай, Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Соёл, урлаг хөгжүүлэх сангийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Тухайн сангийн удирдлага нь санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 2 дугаар сарын 26-наас 2018 оны 3 дугаар сарын 19-ний хооронд хийж, аудитын тайланг 2018 оны 3 дугаар сарын 19-нд эцэслэн



баталгаажуулж, тус сангийн удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, Бодьтусгал-аудит ХХК-ийн аудитор З.Мягмарсүрэн, аудитор Г.Юмчмаа, туслах аудитор Ч.Ариунцэцэг нар хариуцаж хэрэгжүүлэв.

Аудитаар Соёл, урлаг хөгжүүлэх сангийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг 2018 оны 02 дугаар сарын 26-ний өдөр “Бодьтусгал-Аудит” ХХК-д хуулиар тогтоосон хугацаанд хүргүүлсэн байна.

2.3 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Монголын үндэсний болон сонгодог урлагийг хөгжүүлэх, түүх соёлын дурсгалыг хамгаалах, сэргээн засварлах, сурталчлах, соёл, урлагийн ажилтны мэргэжлийг дээшлүүлэх, уран бүтээлчдэд бүтээл туурвих, олон улсын хэмжээнд зохиогддог уралдаан наадамд оролцоход санхүүгийн дэмжлэг үзүүлэхэд сангийн үндсэн зорилго оршдог.

Засгийн газрын 2015 оны “Төсвийн байгууллагуудад хийх бүтэц, зохион байгуулалтын зарим арга хэмжээний тухай” 55 дугаар тогтоолоор Соёл, урлагийг хөгжүүлэх сангийн ажлын албыг татан буулгаж, чиг үүргийг нь Боловсрол, соёл шинжлэх ухааны яаманд шилжүүлсэн.

Соёл, урлагийг дэмжих сангийн дүрмийг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2017 оны А/125 тоот тушаалаар баталжээ. Сангийн дүрэмд “сангаас санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг сонгон шалгаруулах орон тооны бус мэргэжлийн зөвлөлтэй байна” гэж заасны дагуу зөвлөлийн бүрэлдэхүүнийг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2017 оны А/249 дүгээр тушаалаар батлан, ажиллуулж байна.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3-т Энэ хуулийн 6.4-т заасан тусгай сангийн хөрөнгийг захиран зарцуулах шийдвэрийг тухайн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн гаргах бөгөөд энэ хуулийн 6.4.4; 6.4.6;т зааснаас бусад тусгай санд зориулан ажлын алба байгуулж, санхүүжүүлэхийг хориглоно” гэж заажээ. Үүний дагуу ажлын алба байгуулагдаагүй байна.


Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэг, Засгийн газрын 2016 оны 7 дугаар сарын 27-ны өдрийн “Яамдын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаар батлах тухай” 3 дугаар тогтоолыг үндэслэн сайдын 2017 оны 2 дугаар сарын 08-ны А/45 тоот тушаалаар Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын багцын Соёл урлагийг дэмжих сангаас сайдын тушаалаар шийдвэрлэгдэх хөрөнгийн нэгдүгээр гарын үсгийг Санхүү, эдийн засгийн газрын даргын үүрэг гүйцэтгэгч, хоёрдугаар гарын үсгийг салбарын төсвийн ерөнхий нягтлан бодогч нарт зурах эрх олгосон байна

Төсвийн шууд захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой Төсвийн тухай, Соёлын тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулиудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Үйл ажиллагааны стратегийн зорилт:

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт төрөөс соёлын талаар баримтлах бодлого, Соёлын тухай хуулинд тавигдсан үндсэн чиглэлүүдийг хангахын тулд доорх эрхэм зорилгыг хэрэгжүүлэхийн тулд дараах стратегийн тэргүүлэх чиглэлүүдийг тодорхойлж байна. Үүнд:

“Түүх соёлын дурсгалт зүйлийг хамгаалах, Сонгодог урлаг, Ардын урлаг” хөтөлбөрүүд, хүүхдэд зориулсан уран бүтээлийг дэмжиж жил бүр хөгжмийн болон



дүрслэх урлагийн шилдэг бүтээлийг улсын сан хөмрөгт худалдан авч, төв орон нутгийн нийтийн номын сангийн фондыг баяжуулах зэрэг болно.

Соёл урлагийг хөгжүүлэх сангийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд төлөвлөсөн хэмжээнд судалж, баримтжуулсан.

2.4 Аудитын шалгуур үзүүлэлт, АРГА ЗҮЙ, ХЭРЭГЖҮҮЛСЭН ГОРИМ СОРИЛ, ТҮҮНИЙ ҮР ДҮН

Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000 – 1810 буюу Санхүүгийн аудитын удирдамж, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиудыг гол шалгуур болголоо.

Аудитаар Соёл, урлаг хөгжүүлэх сангийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санал дүгнэлт өгөх зорилгоор тэдний бэлтгэсэн санхүүгийн тайлан, сайдын тушаалаар батлуулсан төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн дансдын уламжлалт болон хяналтын эрсдэлийг үнэлж баримтжууллаа.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын 4 чиглэлээр түүвэрчилсэн байдлаар аудитын 6 горим, сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн алдаа, зөрчилтэй зарим гол асуудлыг энэ тайлангийн 2.9 дэх заалтад хураангуйлан тэмдэглэв.

Соёл, урлаг хөгжүүлэх сангийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэл бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтний оролцоо шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ.

Тус сан нь санхүүгийн тайлангаа нягтлан бодох бүртгэлийн “PTreasury” програмаар бэлтгэсэн байна.


2.5 Дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Соёл урлагийг хөгжүүлэх сангийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналтын эрсдэл өндөр байна гэж үзлээ.

2.6 Төсөв болон төлбөрт орлогын гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Соёл, урлаг дэмжих сан байгуулна” гэж заасны дагуу 2017 онд сангийн хөрөнгийг 1,000.0 сая төгрөгөөр батлаж, 990,6 сая төгрөгийн гүйцэтгэлтэй гарсныг Боловсрол соёл шинжлэх ухаан спортын сайдын багцаас шууд санхүүжүүлсэн байна. Тайлант оны эцэст зарцуулагдаагүй үлдэгдэл 9.3 сая төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.



Соёл урлагийг хөгжүүлэх сангаас дараах 4 зориулалтаар санхүүжилтийг олгожээ.

Үүнд:	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
Уран бүтээл хийлгэх	244.0	244.0
Соёл урлаг хөгжүүлэх	408.0	398.6
Монгол уран бүтээл	160.0	160.0
Сонгодог урлаг	188.0	188.0
Нийт	1000.0	990.6

2.7 Шилэн дансны мэдээлэл

Соёл, урлаг хөгжүүлэх сан нь цахим хуудас iom.num.edu.mn/сайтад шилэн дансны цэсийг холбосон. Шилэн дансны сайтад 4 тушаалтай холбоотой 954,2 сая төгрөгийн гүйлгээг шилэн дансанд байршуулсан.

2.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 3 чиглэлээр эрсдэл тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр, нийт 3 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнг гүйцэтгэлийн үе шатны “Төлөвлөсөн горим, сорилуудыг хэрэгжүүлж, үр дүнг аудитын чиглэл тус бүрээр баримтжуулах” гэсэн үе шатны ажилд хамааруулан ТАБ-СТА-В-3 маягтаар данс тус бүрээр баримтжуулсан болно.

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн зарим зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 2.9-д хураангуйлан тэмдэглэв.

2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

2.9.1 Дотоод аудитын зохион байгуулалтын талаар

Тус сангаас хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрийн гүйцэтгэлд тавьсан дотоод хяналтыг хангалтгүй зохион байгуулсан. Үүнд: төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр гүйцэтгэгчтэй хийсэн гэрээнд хяналтыг хэрхэн тавих талаар тодорхой дурдаагүй, ажлын гүйцэтгэлд зөвхөн бодлогын газрын нэг мэргэжилтэн гэрээ дүгнэсэн акт үйлдсэн нь дотоод хяналт хангалттай биш байгааг илэрхийлж байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 “Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд” гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

- Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах талаар зөвлөмж хүргүүлэх;

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

2.10 АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Төсөл хөтөлбөрийн гүйцэтгэлд хяналт тавих талаар холбогдох баримт бичигт тодорхой зүйл байхгүй байна.

2.11 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АСУУДЛУУД

Төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлсэн ажлын гүйцэтгэлийн баримтанд анхаарах

2.12 АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЙН НЭГТГЭЛ

Соёл, урлаг хөгжүүлэх сангийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар материаллаг дүнтэй зөрчил илрээгүй болно.

2.13 ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Соёл, урлаг хөгжүүлэх сангийн үйл ажиллагаа 2016 онд явагдаагүй учир аудитын зөвлөмж гараагүй.

2.14 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР:

Аудитын төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлох бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр зардлын дүнг сонгов.

Соёл урлагийг хөгжүүлэх сангийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн зардлын дүн 990.6 сая төгрөг бөгөөд түүний 1 хувиар буюу 9.9 сая төгрөгөөр материаллаг байдлыг тогтоосон.

2.15 САНАЛ ДҮГНЭЛТИЙН ХЭЛБЭР, ҮНДЭСЛЭЛ

Соёл, урлаг хөгжүүлэх сангийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг баталгаажуулах ажлыг Аудитын олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Соёл, урлаг хөгжүүлэх сангийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээний болон илчлэл тодруулгад тайлагнасан ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж дүгнэн “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргаж байна.

3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

“Бодьтусгал-Аудит” ХХК аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүүгийн хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Энэ нь Соёл урлагийг хөгжүүлэх сангийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан санхүүгийн ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдсан зөвлөмжүүд цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлынх нь дарааллаар эрэмбэлэн дор нэгтгэн харуулав.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

Бодьтусгал-Аудитын ажиглалт

Төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр гүйцэтгэгчтэй хийсэн гэрээнд хяналтыг хэрхэн тавих талаар тодорхой дурдаагүй, ажлын гүйцэтгэлд зөвхөн бодлогын газрын нэг мэргэжилтэн гэрээ дүгнэсэн акт үйлдсэн нь дотоод хяналт хангалттай биш байгааг илэрхийлж байна. Энэ нь “Нягтлан бодох бүртгэлийн тухай” хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-д “Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно” гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

Эрсдэлүүд

Холбогдох хууль тогтоомж, заавар журмыг мөрдөж ажиллахгүй байх;
Төсөвлөсөн хөрөнгийг зориулалтаар зарцуулахгүй байх
Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах

Зөвлөмж

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах;
Гэрээт ажлын гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулах, дотоод хяналтын ажилтнаар давхар хяналтыг тавиулах;
Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 6 дугаар сарын 5 ны өдрийн дотор Үндэсний аудитын газар хүргүүлэх

Үйлчлүүлэгчийн хариу

Гэрээт ажлын гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулж, дотоод хяналтын ажилтнаар гэрээг дүгнүүлж байх байх гэсэн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах болно.

(Төгрөгөөр)

4 Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

4.3 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

	ҮЗҮҮЛЭЛТ	Гүйцэтгэл
83	ТУСЛАМЖ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,000,000,000.00
84	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,000,000,000.00
87	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫИ ДҮН (I)	1,000,000,000.00
88	УРСГАЛ ЗАРДАЛ	990,654,360.00
89	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ	432,000,000.00
90	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	432,000,000.00
137	Бараа үйлчилгээний бусад зардал	558,654,360.00
138	Бараа үйлчилгээний бусад зардал	558,654,360.00
150	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9,345,640.00
154	Бусад урсгал шилжүүлэг	9,345,640.00
163	Төвлөрүүлэх шилжүүлэг	9,345,640.00
180	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,000,000,000.00
181	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	-
191	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	-

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

4.4 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(Төгрөгөөр)

	ҮЗҮҮЛЭЛТ	Гүйцэтгэл
61	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	18,436,038.00
62	11	18,436,038.00
66	Бусад орлого	5,000,000.00
67	Туслах үйлажиллагааны орлого	13,436,038.00
83	ТУСЛАМЖ САНХҮҮГИЙН ОРЛОГО	1,018,436,038.00
84	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,018,436,038.00
85	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,018,436,038.00
86	УРСГАЛ ЗАРЛАГА	1,009,090,398.00
87	БАРАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,009,090,398.00
126	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ	559,500,000.00
127	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	559,500,000.00
136	Бараа үйлчилгээний бусад зардал	449,590,398.00
137	Бараа үйлчилгээний бусад зардал	449,590,398.00
149	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9,345,640.00
153	Бусад урсгал шилжүүлэг	9,345,640.00
163	Төвлөрүүлэх шилжүүлэг	9,345,640.00
164	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (II)	1,018,436,038.00

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2017оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(Төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Зөрүү
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,000,000,000.00	990,654,360.00	9,345,640.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,000,000,000.00	990,654,360.00	9,345,640.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,000,000,000.00	990,654,360.00	9,345,640.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	432,000,000.00	559,500,000.00	(127,500,000.00)
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	432,000,000.00	559,500,000.00	(127,500,000.00)
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	568,000,000.00	431,154,360.00	136,845,640.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	568,000,000.00	431,154,360.00	136,845,640.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,000,000,000.00	990,654,360.00	9,345,640.00
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,000,000,000.00	990,654,360.00	9,345,640.00
310001	Улсын төсвөөс санхүүжих	1,000,000,000.00	990,654,360.00	9,345,640.00

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОХИРУУЛГЫН ТАЙЛАН

(Төгрөгөөр)

Бүртгэлийн дансны код	Бүртгэлийн дансны нэр	Дүн
A	МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАНГИЙН НИИТ ОРЛОГО (ҮАО+ХҮАО+СҮАО)	1,018,436,038.00
	Хасахнь:	
	Урсгал үйлажиллагааны санхүүжилт	9,345,640.00
	Бусад орлого	5,000,000.00
	Туслах үйл ажиллагаанаас	13,436,038.00
B	Тохируулсан орлогын дүн	27,781,678.00
B	ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАНГИЙН ОРЛОГЫН ДҮН (А-Б)	990,654,360.00
Г	МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАНГИЙН НИИТ ЗАРЛАГА (ҮАО+ХҮАО+СҮАО)	1,018,436,038.00
	Зарлагын тохируулга	
	Бараа үйлчилгээний бусад зардал	27,781,678.00
Д	Тохируулсан зарлагын дүн	27,781,678.00
	ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАНГИЙН ЗАРЛАГЫН ДҮН (Г-Д)	990,654,360.00
-	Тохируулгын орлого, зарлагын зөрүү (Б-Д)	-

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

Менежментийн захидлын хариу



**МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ
УХААН, СПОРТЫН ЯАМ**

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Бага тойруу 44, Засгийн газрын III байр,
Утас: 26-22-27, Факс: (976-11) 32-35-89,
E-mail: info@mecss.gov.mn, http:www.mecss.gov.mn

2018.03.20 № 11/2445

танай _____-ны № _____-т

**“БОДЬТУСГАЛ-АУДИТ” КОМПАНИЙ
ЗАХИРАЛ З.МЯГМАРСҮРЭН ТАНАА**

Танай 2018 оны 3 дугаар сарын 19-ны өдрийн 14/18 тоот албан бичигтэй танилцлаа.

Соёл, урлагийг дэмжих сангийн 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар гэрээт ажлын гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулах, дотоод хяналтын ажилтанаар гэрээг дүгнүүлж байх гэсэн зөвлөмжийг хүлээн авч цаашид хэрэгжүүлж ажиллах болно.

САНХҮҮ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗРЫН
ДАРГЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ
Х.ГАЛСАНХҮҮ



03 02743

D:\My doc\GANAA\MECS-WORK\Standart-A5

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**